

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХЭА-2022/146/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чингис хот  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390

Аудитор: Б.Ариунаа  
Утас: 93032714

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	12
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт .....	13
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Төлбөрийн акт .....	13
4.3 Албан шаардлага.....	13
4.4 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.09 № 182  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ  
ЕБС-ИЙН ЗАХИРАЛ Д.СОЛОНГО  
ТАНАА**

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>28,938,942.75</b>	<b>39,032,311.59</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>28,938,942.75</b>	<b>39,032,311.59</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>149,600.00</b>	<b>57,000.00</b>
35130	Эм боох материал	149,600.00	57,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>28,789,342.75</b>	<b>38,975,311.59</b>
35410	Бичиг хэргийн материал	83,500.00	199,936.30
35420	Аж ахуйн материал	13,930,428.00	21,146,040.54
35440	Түлш, шатах тослох материал	960,000.00	2,435,400.00
35460	Хүнсний материал	-	2,080,020.00
35470	Бусад хангамжийн материал	13,815,414.75	13,113,914.75
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>384,634,616.64</b>	<b>398,994,221.90</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>384,634,616.64</b>	<b>398,994,221.90</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>336,334,616.64</b>	<b>350,694,221.90</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	331,966,492.00	331,966,492.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(29,785,938.68)	(47,030,145.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	59,490,191.00	81,020,191.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(38,063,240.94)	(43,652,318.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,841,435.90	34,911,481.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,044,599.54)	(11,685,367.66)
39217	Ном	4,930,276.90	5,163,889.38
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>48,300,000.00</b>	<b>48,300,000.00</b>
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(100,000.00)	(100,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	48,000,000.00	48,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>413,573,559.39</b>	<b>438,026,533.49</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>413,573,559.39</b>	<b>438,026,533.49</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>413,573,559.39</b>	<b>438,026,533.49</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	<b>228,690,952.90</b>	<b>228,690,952.90</b>
51101	Өмч: - төрийн	228,690,952.90	228,690,952.90
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>44,019,290.33</b>	<b>68,472,264.43</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	44,019,290.33	44,019,290.33
51220	Тайлант үеийн үр дүн	-	24,452,974.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	140,863,316.16	140,863,316.16
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>413,573,559.39</b>	<b>438,026,533.49</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>393,822,049.90</b>	<b>346,149,116.54</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>74,953,289.90</b>	<b>22,870,016.54</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>74,953,289.90</b>	<b>22,870,016.54</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	74,953,289.90	22,870,016.54
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	74,953,289.90	22,870,016.54
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>318,868,760.00</b>	<b>323,279,100.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	294,289,060.00	294,304,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	294,289,060.00	294,304,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	221,200.00	4,669,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,597,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	221,200.00	72,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,358,500.00	24,305,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,358,500.00	24,305,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>329,560,929.50</b>	<b>321,696,142.44</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>329,560,929.50</b>	<b>321,696,142.44</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>315,219,970.48</b>	<b>313,133,231.59</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,199,186.81	220,062,881.08
210101	Үндсэн цалин	181,677,320.00	170,061,134.08
210102	Нэмэгдэл	13,013,992.00	29,477,093.00
210104	Урамшуулал	11,542,785.00	15,270,910.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,965,089.81	5,253,744.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,457,148.16	28,740,372.00
210201	Тэтгэврийн даатгал	16,630,933.84	19,725,151.66
210202	Тэтгэмжийн даатгал	1,956,828.08	2,194,331.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,564,932.26	1,755,465.00
210204	Ажилгүйдлийн даатгал	391,297.82	438,866.21
210205	Эрүүл мэндийн даатгал	3,913,156.16	4,626,557.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,840,946.01	17,056,276.07
210301	Гэрэл, цахилгаан	2,975,946.01	3,011,836.07
210302	Түлш, халаалт	16,805,000.00	13,994,440.00
210303	Цэвэр, бохир ус	60,000.00	50,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,699,170.00	4,060,910.00
210401	Бичиг хэрэг	801,600.00	746,010.00
210402	Тээвэр, шатахуун	1,498,770.00	588,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	69,000.00	69,400.00
210404	Ном, хэвлэл	98,200.00	124,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	103,800.00	44,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,127,800.00	1,409,700.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	1,078,900.00
2105	Нормативт зардал	6,376,050.00	8,671,990.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	646,670.00	157,500.00
210502	Хоол, хүнс	4,997,180.00	8,265,990.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	732,200.00	248,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,211,000.00	5,559,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	120,000.00	330,000.00
210602	Тавилга	5,200,000.00	-
210604	Урсгал засвар	4,891,000.00	5,229,400.00
2107	Томилолт, зочны зардал	3,330,000.00	839,000.00
210702	Дотоод албан томилолт	3,330,000.00	839,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.00	432,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	432,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,782,469.50	27,710,402.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	276,900.00	464,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,703,972.00	2,771,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,801,597.50	24,474,052.44
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,340,959.02</b>	<b>8,562,910.85</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,335,020.00	4,388,980.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,235,020.00	3,388,980.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,100,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	66,553.99	165,323.93
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,553.99	165,323.93
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,939,385.03	4,008,606.92
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,939,385.03	4,008,606.92
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>64,261,120.40</b>	<b>24,452,974.10</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>64,261,120.40</b>	<b>24,452,974.10</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>318,868,760.00</b>	<b>323,279,100.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>318,868,760.00</b>	<b>323,279,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>294,289,060.00</b>	<b>294,304,100.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	294,289,060.00	294,304,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>221,200.00</b>	<b>4,669,600.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,597,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	221,200.00	72,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>24,358,500.00</b>	<b>24,305,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,358,500.00	24,305,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>318,868,760.00</b>	<b>306,049,100.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>318,868,760.00</b>	<b>306,049,100.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>305,301,800.98</b>	<b>296,803,489.15</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>218,419,775.00</b>	<b>219,905,381.08</b>
210101	Үндсэн цалин	154,232,483.00	169,903,634.08
210102	Нэмэгдэл	32,019,672.00	29,477,093.00
210104	Урамшуулал	18,129,488.00	15,270,910.00
210105	Гэрээт ажлын хөлс	14,038,132.00	5,253,744.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,236,559.97</b>	<b>28,897,872.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,423,271.91	19,882,651.66
210202	Тэтгэмжийн даатгал	2,203,598.23	2,194,331.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,762,358.32	1,755,465.00
210204	Ажилгүйдлийн даатгал	440,639.75	438,866.21
210205	Эрүүл мэндийн даатгал	4,406,691.76	4,626,557.82
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,400,946.01</b>	<b>18,531,676.07</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,975,946.01	3,011,836.07
210302	Түлш, халаалт	16,365,000.00	15,469,840.00
210303	Цэвэр, бохир ус	60,000.00	50,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,342,770.00</b>	<b>3,496,900.00</b>
210401	Бичиг хэрэг	463,000.00	702,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,498,770.00	588,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	69,000.00	69,400.00
210404	Ном, хэвлэл	98,200.00	241,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	103,800.00	44,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,110,000.00	1,851,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,976,250.00</b>	<b>10,538,710.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	686,870.00	26,900.00
210502	Хоол, хүнс	2,557,180.00	9,663,310.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	732,200.00	848,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,591,000.00</b>	<b>9,578,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	3,970,000.00
210602	Тавилга	5,200,000.00	-
210604	Урсгал засвар	4,891,000.00	5,608,400.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>3,330,000.00</b>	<b>839,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,330,000.00	839,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>324,000.00</b>	<b>432,000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	432,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,680,500.00</b>	<b>4,583,550.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	401,400.00	440,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,279,100.00	4,143,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,566,959.02</b>	<b>9,245,610.85</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,561,020.00</b>	<b>5,071,680.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,461,020.00	4,071,680.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,100,000.00	1,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>66,553.99</b>	<b>165,323.93</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,553.99	165,323.93
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>10,939,385.03</b>	<b>4,008,606.92</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,939,385.03	4,008,606.92
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-</b>	<b>17,230,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>17,230,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>17,230,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>17,230,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж	-	17,230,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-</b>	<b>(17,230,000.00)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>C01</b>	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>228,690,952.90</b>	<b>140,863,316.16</b>	<b>44,019,290.33</b>		<b>413,573,559.39</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	228,690,952.90	140,863,316.16	44,019,290.33	-	413,573,559.39
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн					-
<b>C08</b>	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>228,690,952.90</b>	<b>140,863,316.16</b>	<b>44,019,290.33</b>	-	<b>413,573,559.39</b>
<b>D01</b>	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>228,690,952.90</b>	<b>140,863,316.16</b>	<b>44,019,290.33</b>	-	<b>413,573,559.39</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	228,690,952.90	140,863,316.16	44,019,290.33	-	413,573,559.39
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			24,452,974.10		24,452,974.10
<b>D09</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>228,690,952.90</b>	<b>140,863,316.16</b>	<b>68,472,264.43</b>	-	<b>438,026,533.49</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>318,609,500.00</b>	<b>314,435,569.15</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>318,609,500.00</b>	<b>314,435,569.15</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>313,395,100.00</b>	<b>309,363,889.15</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>221,375,800.00</b>	<b>219,905,381.08</b>
210101	Үндсэн цалин	132,372,600.00	169,903,634.08
210102	Нэмэгдэл	62,978,000.00	29,477,093.00
210104	Урамшуулал	16184000.00	15270910.00
210105	Гэрээт ажлын хөлс	9841200.00	5253744.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,958,600.00</b>	<b>28,897,872.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,103,500.00	19,882,651.66
210202	Тэтгэмжийн даатгал	2,213,800.00	2,194,331.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,771,000.00	1,755,465.00
210204	Ажилгүйдлийн даатгал	442,800.00	438,866.21
210205	Эрүүл мэндийн даатгал	4,427,500.00	4,626,557.82
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,697,000.00</b>	<b>18,531,676.07</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,147,000.00	3,011,836.07
210302	Түлш, халаалт	15,500,000.00	15,469,840.00
210303	Цэвэр, бохир ус	50000.00	50000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,833,200.00</b>	<b>2,829,250.00</b>
210401	Бичиг хэрэг	649,000.00	645,400.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	299,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	69,400.00	69,400.00
210404	Ном, хэвлэл	37,000.00	37,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	44,000.00	44,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,733,800.00	1,733,800.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>10,859,500.00</b>	<b>10,538,710.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,900.00	26,900.00
210502	Хоол, хүнс	9,984,100.00	9,663,310.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	848,500.00	848,500.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>25,108,400.00</b>	<b>25,108,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,500,000.00	19,500,000.00
210604	Урсгал засвар	5,608,400.00	5,608,400.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>849,000.00</b>	<b>839,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	849,000.00	839,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>432,000.00</b>	<b>432,000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,281,600.00</b>	<b>2,281,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	368,500.00	368,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,913,100.00	1,913,100.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,214,400.00</b>	<b>5,071,680.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,214,400.00</b>	<b>5,071,680.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,214,400.00	4,071,680.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>318,609,500.00</b>	<b>314,435,569.15</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>294,304,100.00</b>	<b>290,295,493.08</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	294,304,100.00	290,295,493.08
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>24,305,400.00</b>	<b>24,140,076.07</b>
132001	Орон нутгийн төсвөөс	24,305,400.00	24,140,076.07

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,669,600.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,669,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,669,600.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>667,650.00</b>
210401	Бичиг хэрэг	57,000.00
210402	Тээвэр, шатахуун	288,950.00
210404	Ном, хэвлэл	204,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	117,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,700,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,700,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,301,950.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,230,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,669,600.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,669,600.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,473,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	196,200.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт нь сургалтын чанарыг судлагдахуун бүрээр тодорхой хувиар, ахиулан, хөгжих, төлөвших, боломжийг суралцагсдад олгоход оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус байгууллагын 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 164.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 2.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 1.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12.7 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	28.9	39.0	(10.1)
Үндсэн хөрөнгө	384.6	399.0	(14.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>413.6</b>	<b>438.0</b>	<b>(24.5)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо	413.6	438.0	(24.5)
Засгийн газрын оролцоо /Өмч-Төрийн/	228.7	228.7	-
Өмнөх үеийн үр дүн	44.0	44.0	-
Тайлант үеийн үр дүн	-	24.5	(24.5)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	140.9	140.9	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>413.6</b>	<b>438.0</b>	<b>(24.5)</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 10.1 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 14.4 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Үндсэн хөрөнгийн өсөлт нь үнэ төлбөргүй шилжиж ирсэн болон худалдан авсан тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 438.0 сая төгрөг болж, 24.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 47.7 сая төгрөгөөр буюу 12.1 хувиар буурсан нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлоготой холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 7.8 сая төгрөгөөр буюу 2.4 хувиар буурсан нь цалин хөлс, тогтмол зардал, хангамж, бараа материалын зардалтай холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 458.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 139.7 сая төгрөгөөр бууруулан 318.6 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг тусгай зориулалтын шилжүүлгээс 294.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 24.3 сая төгрөг нийт 318.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 294.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 24.3 сая төгрөг нийт 318.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 314.4 сая төгрөг зарцуулж, 4.0 сая төгрөгийг улсын төсөвт, 0.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 4.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 0.2 сая төгрөг нийт 4.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Онцлох асуудал байхгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитаар илэрсэн гол асуудал байхгүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд байршуулсан мэдээллийг шалгахад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээг 223.7 сая төгрөгөөр мэдээлээгүй.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар бараа материалын тооллого, тооцоо бодолт, анхан шатны баримтын бүрдүүлэлт, хөрөнгийн дахин үнэлгээний үлдэгдлийг үндсэн хөрөнгө тус бүрээр авч үзэх болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 228.9 сая төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 4.7 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 0.4 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 223.8 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

#### **4.1 Залруулсан алдаа**

Бараа материалын орлого, зарлагыг 4.7 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг анхан шатны баримт үндэслэн залруулсан.

#### **4.2 Төлбөрийн акт**

Ээлжийн амралтын хоногийн тооцоо хийгээгүйгээс 0.4 сая төгрөгийн цалинг давхардуулан олгосон.

#### **4.3 Албан шаардлага**

Албан шаардлага өгөгдөөгүй.

#### **4.4 Зөвлөмж**

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээг 223.7 сая төгрөгөөр мэдээлээгүй зөрчил илэрсэн.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны нэгдсэн системд мэдээлбэл зохих мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд, бүрэн мэдээлж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны ЕБС	2	5.1	1	4.7	1	0.4				
<b>ДҮН</b>		<b>2</b>	<b>5.1</b>	<b>1</b>	<b>4.7</b>	<b>1</b>	<b>0.4</b>				
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны ЕБС	1	223.8							1	223.8
<b>ДҮН</b>		<b>1</b>	<b>223.8</b>							<b>1</b>	<b>223.8</b>
<b>НИЙТ ДҮН</b>		<b>3</b>	<b>228.9</b>	<b>1</b>	<b>4.7</b>	<b>1</b>	<b>0.4</b>			<b>1</b>	<b>223.8</b>



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 15/А2370448  
ХЭА-2022/146/НА-СТА-ТЦЗ

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны ЕБС-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ээлжийн амралтын хоногийн тооцоог хийгээгүйгээс 435.7 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна.

Энэ нь ЭМ, НХС-ын 2000 оны хамтарсан тушаалаар батлагдсан "ээлжийн амралт олгох заавар"-ын 13-т "Ажил олгогч нь ажилтанг ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлээгүй ээлжийн амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь::

1. Давхардуулан олгосон 435.7 мянган төгрөгийн цалинг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хэрлэнбаян-Улаан тосгоны ЕБС-ийн захирал Д.Солонго, нягтлан бодогч Д.Отгонцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА

231714297

СЮА0046 9074982